



УЛААНБААТАР ХОТЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай


Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.1, Засгийн газрын 1999 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр, “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр хэсгийн 4.9.9, Хөдөлмөрийн дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.1, Төвийн 2017 оны батлагдсан сургалтын хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төр, засгийн бодлогыг хэрэгжүүлэх, төрийн захиргааны байгууллагыг мэдлэг чадвартай мэргэшсэн албан хаагч бүхий суралцагч байгууллага болгон хөгжүүлж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний үр нөлөө, үр дүнг дээшлүүлэх ажлын хүрээнд тус Төвийн албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх сургалтыг 2017 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг Хүний нөөц, дотоод асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн /Х.Эрдэнэбаяр/-д даалгасугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 850.000 /найман зуун тавин мянга/ төгрөгийг Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Оюунжаргал/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, хамтын ажиллагаа хариуцсан Ахлах мэргэжилтэн /Н.Батсүх/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАН-ОЧИР